



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 5 сарын 25 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 5/1850 дугаар лавлагааг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 28 дугаар тойрогт Хөгжлийн Хөтөлбөр Намаас нэр дэвшүүлсэн Нацагийн Эрхэмбаяр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй тул нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

ДАРГА  Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Ц.БОЛДСАЙХАН

